

*Олон Улс Судлал №3, 2014 он: хуудас 148-150.*

**БНМАУ-ын нутагт байгаа Зөвлөлтийн  
төмөр замын шугамуудыг  
Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн  
“Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгт  
шилжүүлэх тухай хэлэлцээр**

Улаанбаатар хот  
дүгээр сарын 23.

1956 оны 4

БНМАУ-ын Засгийн Газар ба ЗСБНХУ-ын Засгийн Газар нь найрамдлын зарчмыг удирдлага болгон, тус хоёр орны хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөх зорилгоор дор дурдсан зүйлийн тухай хэлэлцэн тохиролцсон нь:

Нэгдүгээр зүйл.

ЗСБНХУ-ын Засгийн газар нь БНМАУ-ын нутагт байгаа Зөвлөлтийн төмөр замын шугамууд:

Эрэнцав-Баянтүмэн (замын өргөн нь 1524 мм, урт нь 286 км).  
Баянтүмэн-Тамсагбулаг (замын өргөн нь 750мм, урт нь 380,5км )-ын төмөр замын шугамуудыг албаны бүх байшин, барилга ба нарийн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, мөн дурьдсан төмөр замуудын балансад байгаа бусад эд хогшлын хамт монгол-зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгт үнэ төлбөргүй шилжүүлэн өгнө.

Хоёрдугаар зүйл.

БНМАУ-ын Засгийн Газар нь энэ хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан төмөр замын шугамууд, байшин, барилгуудын эзэлж байгаа газар ба замын хажуугийн зурвас газрыг монгол-зөвлөлтийн

## ОЛОН УЛС СУДЛАЛ

хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгт хугацаагүй ашиглуулахаар, үнэ төлбөргүй шилжүүлэн өгнө.

Гуравдугаар зүйл.

Энэ Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд дурьдсан төмөр замын шугамууд, байшин, барилгууд, эд хөрөнгийг балансын үнээр, хүлээлгэн өгөх үеийн жинхэнэ элэгдлийг харгалзан, шилжүүлэх болно.

Шилжүүлэн өгч байгаа төмөр замын шугамууд, байшин, барилгуудын ба эд хогшлын үнэ, түүнчлэн замын хажуугийн зурвас газар ба байшин барилгуудын эзэлж байгаа газрыг хугацаагүй ашиглахын нийт татварын дүнг тодорхойлохын тулд хоёр талаас тэгш үндсэн дээр Монгол-Зөвлөлтийн хамтарсан комиссыг байгуулна.

Төмөр замын шугамууд, байшин барилгууд, эд хогшил, тэдгээрийн эзэлж байгаа газар ба замын хажуугийн зурвас газрыг дурдсан комиссоос 1956 оны 8 дугаар сарын 1-нээс хожимдуулалгүйгээр хувь нийлүүлсэн нийгэмлэгт, тусгай акт тогтоож, шилжүүлэх болно.

Дөрөвдүгээр зүйл.

Хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь энэ хэлэлцээрийн гуравдугаар зүйлд заасан ёсоор Монгол-Зөвлөлтийн хамтарсан комиссоос тодорхойлох, төмөр замын шугамууд, байшин, барилга, эд хогшлын бүх үнэ ба замын хажуугийн зурвас газар, зам ба орон барилгын эзэлж байгаа газрыг хугацаагүйгээр нийт татварын дүнгээр нэмэгдэх бөгөөд тэгэхдээ уг мөнгөний 50%-ийг хувь нийлүүлсэн хөрөнгийн монголын хувьд, 50%-ийг зөвлөлтийн хувьд тус тус оруулна.

Тавдугаар зүйл.

Энэ хэлэлцээрээр шилжүүлэн өгч байгаа Эрэнцав-Баянтүмэний төмөр замын шугамыг хэвийн байдалтай ашиглах зөвлөлтийн тал нь төмөр замын ачааны ба зорчигчдын харилцааны тухай олон улсын хэлэлцээрт (АХОХ ба ЗХОХ) тохирох нөхцлөөр өргөн замын хөдлөх бүрэлдэхүүнийг Нийгэмлэгт өгч болно.

## ОЛОН УЛС СУДЛАЛ

Зургаадугаар зүйл.

Эрэнцэв-Баянтүмэний төмөр замын шугамаар ЗСБНХУ-аас БНМАУ-д ирэх, БНМАУ-аас ЗСБНХУ-д очих ачаа ба зорчигчдыг тээвэрлэхэд төмөр замын ачааны ба зорчигчдын харилцааны тухай олон улсын хэлэлцээрийн (АХОХ ба ЗХОХ) нөхцлүүд холбогдно.

Долдугаар зүйл

Энэ хэлэлцээрээр хувь нийлүүлсэн нийгэмлэгт шилжиж байгаа төмөр замын шугамууд, байшин барилга тэдгээрийн эзэлж байгаа газар, замын хажуугийн зурвас газар нь эдгээрийг шилжүүлэхээс өмнө гарсан ямар нэгэн өр, гомдлоос чөлөөлөгдөнө.

Наймдугаар зүйл.

Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн ашиглалтын хэрэгцээний тоноглол ба материалуудыг ЗХУ-аас Монголын байгууллагуудад нийлүүлэх явдал нь 1956 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн Монгол-Зөвлөлтийн худалдааны хэлэлцээрийн үнэ ба нөхцлүүдээр гүйцэтгэгдэнэ.

Есдүгээр зүйл.

Энэ хэлэлцээрт гарын үсэг зурмагц БНМАУ-ын Засгийн Газар ба ЗСБНХУ-ын газрын хооронд байгуулсан Эрэнцэв-Баянтүмэний төмөр замыг ашиглах тухай 1941 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн Гэрээ хүчингүй болно.

Энэ хэлэлцээрийг 1956 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, орос хэл дээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёулаа адил хүчинтэй байна.

Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974.

Баримт материал. Хоёрдугаар боть.

1941-1974. Нэгдүгээр хэсэг.

УБ., 1981. т.255-257.